

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байдал

*Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн НҮТББ**

АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Эрдэс баялгийн салбарт Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх эрх зүйн шинэчлэлийн үйл явц 2020 оноос хойш өрнөж байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (цаашид АҮЭБЯ гэх) 2020-2024 онд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, олон нийтэд танилцуулж байсан боловч Улсын Их Хурал (цаашид УИХ гэх)-д өргөн мэдүүлээгүй билээ. Харин 2025 онд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, 2026 оны 02 дугаар сард олон нийтэд танилцуулж, 05 сарын 27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлээд байна.

2020-2024 онд явагдсан хуулийн төсөл боловсруулах үйл явцыг харахад Хууль тогтоомжийн тухай хууль (цаашид ХТТХ гэх)-д заасан судалгаа, шинжилгээнд үндэслэх зарчим болон бусад холбогдох нарийвчилсан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байв. Тодруулбал, 2023 онд тус хуулийн шинэчилсэн

найруулгын төслийг боловсруулахад “Ашигт малтмалын хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан” болон “Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ”-г тус тус боловсруулж, танилцуулж байсан бөгөөд эдгээр судалгаа нь цуглуулсан мэдээллийн эх сурвалж тодорхой бус, захиргааны байгууллага шинээр байгуулах, эрх мэдлийг нэмэгдүүлэх талаар санал болгосон ч энэ талаараа хангалттай үндэслэл дурдаагүй, үр нөлөөг нь үнэлээгүй байв.

Харин 2026 онд өргөн мэдүүлээд буй хуулийн төсөлд шаардлагагүй суурь судалгааг давхардуулан гүйцэтгэж, 2023 онд гүйцэтгэсэн судалгааны хэсгүүдийг ашигласан байв. Эдгээр судалгаанууд нь агуулгын хувьд давхардсан, цуглуулсан мэдээллийн эх сурвалж тодорхой бус хэвээр байхаас гадна хуулийн төслийг 2026 оны 02 дугаар сард олон нийтэд танилцуулж, орон нутагт хэлэлцүүлэг хийсний дараа

* Судлаач: Б.Мягмарсүрэн, М.Маралмаа, Р.Оюундэлгэр

Шүүмж бичсэн: Р.Хатансайхан, хуульч, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан. Захиргаа, нийтийн эрх зүй, хууль зүйн техник чиглэлээр дагнан судалгаа шинжилгээ хийдэг. Засгийн газрын 59 дүгээр тогтоолын аргачлалаар мэргэшсэн судлаач.

04 дүгээр сард судалгааны тайланг нийтэд нээлттэй болгосноос харахад Үзэл баримтлал ба хуулийн төсөл боловсруулахаас өмнө хийх ёстой зарим судалгааг сүүлд нь нөхөж хийсэн байх магадлалтай байна.

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын гол салбар тул Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа

ХУУЛИЙН ТӨСӨЛ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болохын хувьд ХТТХ-ийн 51 дүгээр зүйлийн 51.1-т заасны дагуу хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, тухайн хуулийг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох учиртай.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд тулгуурлан хуулийн Үзэл баримтлал болон төслийг боловсруулж, тухайн хуулийг хэрэгжүүлснээр гарах үр нөлөө, хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцоог мөн тодорхой аргачлалын дагуу гүйцэтгэсэн байх ёстой.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 04 сарын 29-ний өдөр Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд нийтлэхээс өмнө зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн шатанд дээрх судалгаа, шинжилгээний тайлан олон нийтэд ил тод бус байв. Тодруулбал, АҮЭБЯ-аас 2026 оны 02 дугаар сард аймаг, нийслэлд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчдод 2023 онд боловсруулсан шинэчилсэн найруулгын төслийн судалгааны тайлангуудыг хавсарган хүргүүлсэн байна.¹ Үүнд:

баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий судалгаанд суурилах нь нэн чухал юм.

Иймд энэхүү дүн шинжилгээний хүрээнд УИХ-аар хэлэлцэгдэж буй Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь ХТТХ-д заасан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчимд нийцэж буй эсэхийг дүгнэлээ.

- Ашигт малтмалын хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан
- Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

Эдгээр судалгаа нь 2023 онд боловсруулсан шинэчилсэн найруулгын төслийн үед хийгдсэн бөгөөд агуулгын хувьд одоо өргөн мэдүүлээд буй нэмэлт, өөрчлөлтийн төсөл, түүний үзэл баримтлалаас нэлээд зөрүүтэй. Тодруулбал, нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2026 оны 02 дугаар сард анх олон нийтэд танилцуулж, санал авах үед ХТТХ-д заасан холбогдох судалгааг хийгээгүй байсан гэж үзэх үндэслэл байгаа болно.

Харин хуулийн төслийг 2026 оны 04 сарын 29-ний өдөр Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулахад холбогдох судалгааны тайланг хавсаргажээ. Иймд энэхүү шинжилгээгээр Эрх зүйн мэдээллийн санд хуулийн төслийн хамт байршсан доорх судалгаанууд нь ХТТХ болон Засгийн газрын 2016 оны 01 сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалд нийцэж буй эсэхийг дүгнэв. Үүнд:

1. Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан

¹ УУХҮЯ нь 2023 оны 06 сарын 16-ны өдөр “Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд авах зөвлөх үйлчилгээ” нэртэйгээр, УУХҮЯ/202312011 тендер шалгаруулалтын дугаартай, 135,307,000 төгрөгийн төсөвт өртөгтэй ч, тухайн багц нь 30,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж байжээ, <https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1686644516580>. Тус тендерийн материалд “Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийн талаарх судалгааг хийж, хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулж үр нөлөө, үнэлгээ, зардлын тооцоог хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагын саналыг авч эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж ажлын даалгаврыг тодорхойлсон.

2. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны судалгаа

3. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан зэрэг багтана.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төсөлд хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгаа болон хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хамт хийжээ. Угтаа тус төсөл нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болохын хувьд ХТгХ-ийн 51 дүгээр зүйлийн 51.1-т заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх бөгөөд хэрэгцээ шаардлагын тандан судалгаа хийх шаардлагагүй юм. Учир нь хэрэгцээ шаардлагын тандан судалгааг анхдагч хуулийн төсөл болон хуульд зарчмын шинжтэй өөрчлөлт оруулахуйц шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад хийхээр² хуульчилсан. Иймд энэхүү шинжилгээнд хуулийн төсөлд хавсаргасан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан”-г хамруулаагүй болно.

Харин “Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан”-г ХТгХ болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 06 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалтай харьцуулан дүгнэлээ. Уг тайланг 2026 оны 6 сарын 02-ны өдөр <https://d.parliament.mn/> -д сайтад байршуулсан байна.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үйл явцыг ХТгХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.6, 51 дүгээр зүйлийн 51.2³, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалаар зохицуулж байна. Дээрх аргачлал нь хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх үе шат, тэдгээрт баримтлах нарийвчилсан шаардлагуудыг тогтоосон байдаг.⁴ Тухайлбал, уг үнэлгээг “төлөвлөх”, “хэрэгжүүлэх”, “үнэлэх үе” гэсэн гурван үе шатаар хийх ба “төлөвлөх”

шатанд үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, мэдээлэл цуглуулах аргыг сонгодог бол, “хэрэгжүүлэх” үе шатанд үнэлгээнд шаардагдах мэдээллийг цуглуулж,⁵ “үнэлэх” үе шатанд төлөвлөх үе шатанд тодорхойлсон асуудлуудыг хэрэгжүүлэх шатанд цуглуулсан мэдээллийн дагуу дүгнэнэ.

Эдгээр үе шатыг бүрэн баримтлаагүй, хэлбэрийн төдий гүйцэтгэсэн хуулийг Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгосон тохиолдол гарч байв. Тухайлбал, 2023 онд Үндсэн хуулийн цэц Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэсэн 2023 оны 04 тоот дүгнэлтийн Үндэслэл хэсэгт “... Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох судалгаа бүрдүүлбэрийн хамт өргөн мэдүүлсэн байх боловч дүгнэлт, судалгаа нь иж бүрэн бус, бодит байдалд нийцээгүй, түүнчлэн тухайн хуулиар зохицуулах харилцаанд оролцогч талуудын эрх зүйн байдал болон улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх асуудлыг тусгаагүй байна...” гээд, “...бүрэн бус судалгаанд үндэслэн, татварын суурийг өргөжүүлэхдээ газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд холбогдуулан онцгой албан татварыг шатлалгүйгээр тогтоосон нь түүхий эд импортолж байгаа үндэсний үйлдвэрлэгч нарт ялгамжтай байдал бий болгосон байна. Энэ нь Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчмыг зөрчиж, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг

² Хуулийн төсөлд хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгаа болон хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хамтад нь оруулсан нь тус хуулийн төсөл зарчмын шинжтэй өөрчлөлт агуулсан эсхүл агуулаагүй нэмэлт, өөрчлөлт аль болох нь тодорхойгүй байдлыг бий болгожээ. Эдгээр судалгааны тайланд тус хуулийн төслийг “хуульд зарчмын шинжтэй ямар зохицуулалт шинээр нэмж тусгаж буй” гэж тодорхойлсон зүйл байхгүй, энэ талаар дурдаагүй байна.

³ Хууль тогтоомжийн тухай хууль, 2015, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

⁴ Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал, 2016, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338&showType=1>

⁵ Мөн тэнд.

хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар заасанд нийцэхгүй байна” гэж дүгнэжээ.⁶

Цэцийн уг шийдвэр нь хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлж буй судалгааны дүгнэлт ХТТХ

Төлөвлөх үе шатад аргачлалыг баримталсан байдал

Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ “төлөвлөх” үе шатны зарим шаардлагыг хэрэгжүүлээгүй буюу хуулийн хэрэгжилтийг яагаад, ямар хүрээнд үнэлэх шаардлагатай болсныг тодорхойлоогүй

болон Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалд үндэслэсэн, иж бүрэн, бодит байдалд нийцсэн байх шаардлагыг хангасан байх жишгийг тогтоосон юм.

байна. Тэрчлэн аргачлалд заасан шалгуур үзүүлэлтийг дутуу сонгосон ба сонгон авсан үзүүлэлтийг хэрхэн томъёолж, үнэлгээнд ашигласан нь тодорхойгүй байна.

Хүснэгт 1. Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд төлөвлөх үе шатыг хэрэгжүүлсэн байдал.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний төлөвлөх үе шатад авч хэрэгжүүлэх ажиллагаа	Хэрэгжилт
Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	Хэрэгжүүлсэн
Үнэлгээ хийх хүрээг тогтоох	Хэрэгжүүлээгүй
Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	Дутуу хэрэгжүүлсэн
Харьцуулах хэлбэрийг сонгох	Хэрэгжүүлээгүй
Шалгуур үзүүлэлтийг томъёолох	Хэрэгжүүлээгүй
Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	Хэрэгжүүлээгүй

Аргачлалд заасан шалгууруудаас хүлээн зөвшөөрөгдсөн байдал, зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж буй байдал гэсэн шалгууруудыг сонгон авахын хамт нийгэм, эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл, эрсдэл, сорил, хэрэгжилтийн саад гэсэн нэмэлт шалгуур гарган үнэлгээ хийжээ. Харин зардлын өсөлт,

бууралт болон зардал, үр өгөөжийн харьцаа гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгоогүй. Иймээс АМТХ-иар зохицуулдаг АМНАТ-ийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлээгүй. Гэвч хуулийн төсөлд АМНАТ-ийн хувь, хэмжээг өөрчлөх тухай зохицуулалт туссан байна.

Хэрэгжүүлэх үе шатад аргачлалыг баримталсан байдал

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд зааснаар “хэрэгжүүлэх” үе шатны гол зорилго нь үнэлгээнд шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах явдал юм. Цуглуулсан мэдээлэл нь хангалттай, зайлшгүй шаардлагатай буюу хамааралтай, бодитой байх шаардлагатай.⁷ Учир нь тухайн асуудалд хамааралтай, бодитой бөгөөд хангалттай мэдээлэлгүй бол хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг бүрэн дүүрэн тодорхойлох боломжгүй. Энэ ч утгаараа

хэрэгжүүлэх үе шатны гүйцэтгэл нь үнэлгээний үр дүнд шууд нөлөөлнө.

Гэвч 2025 онд хийсэн Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд “хэрэгжүүлэх” үе шатанд ямар мэдээлэл цуглуулсан нь тодорхойгүй бөгөөд үнэлгээний дүгнэлтүүдийг ямар тоо баримт, судалгаанд тулгуурлан гаргасныг огт тайлбарлаагүй. Ийнхүү уг үнэлгээг гүйцэтгэхдээ “хэрэгжүүлэх” үе шатыг алгассан нь дараагийн

⁶ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Дугаар 04, Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759594612931>.

⁷ Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал, 2016, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338&showType=1>

шат буюу “үнэлэх” үе шатны гүйцэтгэл, үр дүнд сөргөөр нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл, тайланд дурдсан дүгнэлтүүд нь ямар баримт,

мэдээлэлд тулгуурласан болох нь тодорхойгүй, үндэслэлгүй байна.

Үнэлэх үе шатанд аргачлалыг баримталсан байдал

Дээр өгүүлсэнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ “хэрэгжүүлэх үе шат”-ыг бүрэн алгассан нь үнэлгээний эцсийн үр дүн, ач холбогдлыг бууруулжээ. Үүнд:

- Тайланд дурдсан дүгнэлтүүд ямар нэг тоо баримт, мэдээлэлд үндэслээгүй буюу судалгааны аргачлалд заасан шаардлагад нийцээгүй. Өөрөөр хэлбэл, энэ шатанд Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг

хуулийн бүлэг тус бүрээр үнэлэн дүгнэлт өгсөн байх боловч чухам яагаад тухайн дүгнэлтэд хүрсэн нь тодорхойгүй.

- Үнэлгээг долоон бүлэг асуудлаар хийсэн байх боловч бүх асуудалд нэг ижил дүгнэлт өгсөн нь үнэлгээг зохих ёсоор гүйцэтгээгүйг илтгэж байна. Тэрчлэн эдгээр дүгнэлт нь хэт ерөнхий байгаа нь цаашид хууль тогтоомжийг сайжруулахад ач холбогдол багатай.

Зураг 1. Давтагдсан дүгнэлтүүд⁸

2.1. Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг бүлэг тус бүрээр үнэлэх:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

2020-2025 онд уг бүлгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн түвшин дунд зэрэг байна Хууль хэрэгжилтийн явцад зарим зохицуулалт бодит байдалтай зөрчилдөх, орон нутгийн хэрэгжилт хангалтгүй. бодлогын уялдаа сул байгаа нь илэрсэн. Гэсэн хэдий ч төрийн хяналтын тогтолцоо. лицензийн ил тод байдлын зэрэг чиглэлд ахиц гарсан байна.

Хоёрдугаар бүлэг. Ашигт малтмал эрэх. хайх үйл ажиллагаа

2020-2025 онд уг бүлгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн түвшин дунд зэрэг байна Хууль хэрэгжилтийн явцад зарим зохицуулалт бодит байдалтай зөрчилдөх, орон нутгийн хэрэгжилт хангалтгүй. бодлогын уялдаа сул байгаа нь илэрсэн. Гэсэн хэдий ч төрийн хяналтын тогтолцоо. лицензийн ил тод байдлын зэрэг чиглэлд ахиц гарсан байна.

Гуравдугаар бүлэг. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа

2020-2025 онд уг бүлгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн түвшин дунд зэрэг байна Хууль хэрэгжилтийн явцад зарим зохицуулалт бодит байдалтай зөрчилдөх, орон нутгийн хэрэгжилт хангалтгүй. бодлогын уялдаа сул байгаа нь илэрсэн. Гэсэн хэдий ч төрийн хяналтын тогтолцоо. лицензийн ил тод байдлын зэрэг чиглэлд ахиц гарсан байна.

Дөрөвдүгээр бүлэг. Тусгай зөвшөөрөл ба лицензийн зохицуулалт

2020-2025 онд уг бүлгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн түвшин дунд зэрэг байна Хууль хэрэгжилтийн явцад зарим зохицуулалт бодит байдалтай зөрчилдөх, орон нутгийн хэрэгжилт хангалтгүй. бодлогын уялдаа сул байгаа нь илэрсэн. Гэсэн хэдий ч төрийн хяналтын тогтолцоо. лицензийн ил тод байдлын зэрэг чиглэлд ахиц гарсан байна.

Тавдугаар бүлэг. Ашиглалтын төлбөр, татвар, орлогын хуваарилалт

2020-2025 онд уг бүлгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн түвшин дунд зэрэг байна Хууль хэрэгжилтийн явцад зарим зохицуулалт бодит байдалтай зөрчилдөх, орон нутгийн хэрэгжилт хангалтгүй. бодлогын уялдаа сул байгаа нь илэрсэн. Гэсэн хэдий ч төрийн хяналтын тогтолцоо. лицензийн ил тод байдлын зэрэг чиглэлд ахиц гарсан байна.

Зургаадугаар бүлэг. Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлт

2020-2025 онд уг бүлгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн түвшин дунд зэрэг байна Хууль хэрэгжилтийн явцад зарим зохицуулалт бодит байдалтай зөрчилдөх, орон нутгийн хэрэгжилт хангалтгүй. бодлогын уялдаа сул байгаа нь илэрсэн. Гэсэн хэдий ч төрийн хяналтын тогтолцоо. лицензийн ил тод байдлын зэрэг чиглэлд ахиц гарсан байна.

Долоодугаар бүлэг. Хяналт шалгалт, хариуцлага

2020-2025 онд уг бүлгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн түвшин дунд зэрэг байна Хууль хэрэгжилтийн явцад зарим зохицуулалт бодит байдалтай зөрчилдөх, орон нутгийн хэрэгжилт хангалтгүй. бодлогын уялдаа сул байгаа нь илэрсэн. Гэсэн хэдий ч төрийн хяналтын тогтолцоо. лицензийн ил тод байдлын зэрэг чиглэлд ахиц гарсан байна.

Ийнхүү харилцан адилгүй асуудалд үг үсгийн зөрүүгүй ижил дүгнэлт хийж, давтан бичсэн

ба тоо баримт, хууль хэрэгжих хугацаанд хийгдсэн бусад судалгаа, тайлан, статистик,

⁸ Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан, 2025 он, 4-5 хуудас, <https://d.parliament.mn/tusul/a8d32cbf-db26-4572-9c4a-695d7fe5fafa>


холбогдох талуудын санал шүүмж, байр суурь, шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, хэвлэл

мэдээллийн эх сурвалжийг огт ашиглаагүй нь судалгааг маш богино хугацаанд хэлбэрийн төдий, чанаргүй хийж гүйцэтгэснийг харуулж байна.

ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ НЬ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНД ҮНДЭСЛЭСЭН БАЙДАЛ

2015 оны Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-8.1.9-д хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатыг хуульчилсан.

Зураг 2. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат



Дээрх зургаас үзвэл, хуулийн төсөл боловсруулах ажиллагааны 8 үе шатны эхлэл нь хууль, тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох юм. Анхдагч хууль болон аливаа хуулийн Үзэл баримтлалыг өөрчлөхүйц зарчмын шинжтэй шинэчлэл хийх тохиолдолд хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа хийх бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилжбуй хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлнэ. Эдгээр судалгаанд үндэслэн хуулийн төслийн Үзэл баримтлалыг боловсруулна. Үүнийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 7

дугаар зүйлийн 7.3, 8 дугаар зүйлийн 8.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх заалтаар дэлгэрүүлэн зохицуулжээ.

Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын анхдагч шат нь судалгаа бөгөөд судалгааны дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан дараа дараагийн үе шатыг үргэлжлүүлэх ёстой. Хэрэгжилтийн үр дагаварт дурдагдаагүй асуудлыг хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөлд оруулах нь ХТТХ-д нийцэхгүй.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 сарын 02-ны өдөр <https://d.parliament.mn/>-д сайтад байршуулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Үзэл баримтлал болон хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний агуулгыг харьцуулан шинжилбэл:

Хуулийн төсөл санаачлагчийн 2025 онд гүйцэтгэсэн “Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан”-д дараах 5 асуудлыг судалсан байна. Үүнд:

- 1) Стратегийн ач холбогдол бүхий орд;
- 2) Орон нутгийн оролцоо;
- 3) Байгаль орчны нөхөн хамгаалалт ба нөхөн сэргээлт;
- 4) Баяжуулалтын бодлого;
- 5) Ил тод байдал ба авлигын эрсдэл.⁹

Харин Ашигт малтмалын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслөөр дараах 6 асуудлыг хамруулсан. Үүнд:

- 1) Чухал ашигт малтмалын тодорхойлолт, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны зохицуулалт;
- 2) Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг зэрэг баяжуулах үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцаа;
- 3) Геологийн судалгааны ажлыг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, гэрээт ажлын үр дүнг

үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох харилцаа;

- 4) Нутгийн захиргааны байгууллагатай харилцах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр, бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой зохицуулалт;
- 5) Засгийн газар, төрийн захиргааны байгууллага, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг;
- 6) Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн баталгаа, төлөвлөгөө боловсруулах.¹⁰

Дээрхээс үзвэл, Ашигт малтмалын тухай хуулийн 2025 оны хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дүгнэлт болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн агуулга хоорондоо ялгаатай байна. Үнэлгээний зөвлөмжид дурдсан стратегийн орд газар, ил тод байдал, авлигаас сэргийлэх асуудлыг хуулийн Үзэл баримтлал, төсөлд тусгаагүйн зэрэгцээ чухал ашигт малтмал, геологийн суурь судалгааг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, гэрээт талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох зэрэг судалгаанд хамрагдаагүй асуудлыг хуулийн төсөлд зохицуулалт болгож оруулсан.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь хууль тогтоомжийн боловсруулах үе шатыг зөрчсөн, судалгаанд тулгуурлах шаардлагад нийцэхгүй болохыг илтгэж байна.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төслийг боловсруулсны дараа үр нөлөөний үнэлгээ хийнэ. Ийнхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх нь боловсруулж байгаа хууль тогтоомжийн төсөл нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой ямар нэг байдлаар зөрчилдсөн, давхардсан зохицуулалт агуулж буй эсэх, эсвэл тухайн хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг

орхигдуулж хийдэл үүсгэх эсэхийг сайтар шалгаж, хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах буюу чанарыг сайжруулах зорилготой.¹¹

Үр нөлөөний үнэлгээний тайлан нь хуулийн төслийн бүрдүүлбэрт хамаарах гол баримт бичгийн нэг юм. Харин Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг <https://d.parliament.mn/>-д

⁹ Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2025, 8-17 дахь талыг үзнэ үү.

¹⁰ Ашигт малтмалын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 4 дэх тал

¹¹ Монгол Улсын Засгийн газар, 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, 2016, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335>

сайтад байршуулахдаа төслийн үр нөлөөний үнэлгээг байршуулаагүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтыг зөрчсөн байна.¹² Харин Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр байршуулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хавсралт файлд төслийн үр нөлөөг байршуулсан.¹³

Төслийн үр нөлөөний судалгааг гүйцэтгэхэд салбарын мэргэжилтнүүдтэй уулзалт, зөвлөгөөн хийх, тухайн асуудалтай холбоотой ном, хэвлэл, судалгааны материал зэргийг ашиглах, цаашлаад хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх талууд, төрийн бус байгууллагаас санал авах, ярилцлага, хэлэлцүүлэг хийж,¹⁴ хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийн төслийн чанарыг сайжруулах зөвлөмж боловсруулна.

Гэвч Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээнд эдгээр аргыг ашиглаагүй. Өөрөөр хэлбэл, тус төслийн үр нөлөөний тайланд салбарын холбогдох мэргэжилтнүүд, хуулийн төслийг хэрэгжилтэд хамаарах этгээдүүдийг оролцуулсан эсэх нь тодорхойгүйгээс гадна үнэлгээний эцэст өгсөн зөвлөмж нь хуулийн

төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалгаа болон хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, үзэл баримтлалын агуулгыг давтсан шинжтэй, тус судалгааны өөрийн онцлогийг илтгэсэн зүйлгүй байна.

Үр нөлөөний үнэлгээний зарим дүгнэлтүүд хоорондоо агуулгын зөрчилтэй байгаа нь судалгааг зохих ёсоор хийгээгүй, чанарын шаардлага хангахгүй байна. Тухайлбал, тайлангийн 3.2 дахь хэсэгт “хуулийн төслийн 421.2-д тусгасан зохицуулалт нь иргэн, төрийн бус байгууллагад үүрэг болгосон зохицуулалт байна. Мөн “явцуу ашиг сонирхол” гэдгийг хэрхэн ойлгох, хэн тогтоох нь тодорхойгүйн улмаас иргэдийн эрх хөндөгдөх эрсдэл үүсэхээр байна” гэж дүгнэсэн байна. Гэсэн хэдий ч тайлангийн 3.4 дэх хэсэг “Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх” гэсэн асуултад “Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй” хэмээн дээр дурдсантай зөрчилтэй дүгнэлт хийжээ.

Үр нөлөөний үнэлгээгээр хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт агуулсан эсэхийг шалган тогтоох шаардлагатай. Харин бусад хууль тогтоомжтой давхардсан буюу зохицуулалтын нэмэлт ач холбогдолгүй дараах зохицуулалт туссаныг анхаараагүй.

Хүснэгт 2. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийсэн хувилбар буюу Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршсан хувилбарын 42¹ дугаар зүйлд туссан бусад хууль тогтоомжтой давхардсан заалтууд

Хуулийн төслийн заалт	Бусад хуулиар зохицуулагдсан байдал
42 ¹ .2.1.салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгт оролцох, санал, зөвлөмж өгөх;	Төрийн бодлого, шийдвэр үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зохицуулалт дараах хууль тогтоомжоор нэгэнт зохицуулагдсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын тухай хууль, - Хууль тогтоомжийн тухай хууль, - Захиргааны ерөнхий хууль, - Нийтийн сонсголын тухай, - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль.

¹² Монгол Улсын Засгийн газар, Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, <https://d.parliament.mn/tusul/a8d32cbf-db26-4572-9c4a-695d7fe5fafa>

¹³ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, https://legalinfo.mn/mn/discussiondetail/17436602043482?type=LIS_LAW&page=3

¹⁴ Монгол Улсын Засгийн газар, 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.5.1, 4.8.1-ыг үзнэ үү, 2016, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335>

Хуулийн төслийн заалт	Бусад хуулиар зохицуулагдсан байдал
42 ¹ .2.4.холбогдох төрийн байгууллагаас геологи, уул уурхайн салбарын талаар үнэн, зөв мэдээлэл авах;	Иргэдийн мэдээлэл авах, эрж хайх эрх, түүнийг хэрэгжүүлэх үйл явцыг дараах хуулиудаар нарийвчлан зохицуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах журмын тухай хууль, - Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, - Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, - Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйл болон бусад.
42 ¹ .2.6.ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдэгдэх, гомдол гаргах.	Иргэдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хуулийн зөрчлийг арилгуулах өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргах эрх, түүнийг хянан шийдвэрлэх үйл явц дараах хуулиар нэгэнт зохицуулагдсан тул давхардуулах шаардлагагүй. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Захиргааны ерөнхий хууль, - Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах журмын тухай хууль, - Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, - Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, - Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, - Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, - Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад.
Зөрчлийн тухай хуульд “геологи, уул уурхай, газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хууль бусаар халдаж, тоног төхөөрөмж эвдсэн, үйлдвэрлэлийг санаатайгаар тасалдуулсан, зам, уурхайн гарц хаасан, цахилгаан хангамж, усан хангамжийг зориуд тасалсан” бол хариуцлага хүлээлгэх заалт нэмэхээр тусгажээ.	Харин дээрх харилцаа нь Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар аль хэдийн зохицуулагдсан, хамгаалагдсан харилцаа тул давхардуулан зохицуулах боломжгүй. Тодруулбал, Эрүүгийн хуулиар бусдын эд хөрөнгийг санаатай болон болгоомжгүйгээр устгасан, гэмтээсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон ¹⁵ бол Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй нөхцөлд Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэж байна. ¹⁶ Тэрчлэн Зөрчлийн тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд хууль бусаар саад учруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжтой байна. ¹⁷

Үр нөлөөний үнэлгээгээр хуулийн төсөл нь Үзэл баримтлалд нийцсэн эсэхийг тогтоох учиртай ч энэ шаардлагыг хангахгүй байна. Учир нь хуулийн төслийн Үзэл баримтлалд уг хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт буюу Зургаадугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийн нийцүүлэх хуваарь”-ийн 1.1 дэх хэсэг болохыг дурдсан.

Гэтэл хуулийн төсөлд Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан “мэдэх эрх”, УИХ-ын дээрх тогтоолоор батлагдсан хуваарьт заасан “онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгох”-д чиглэсэн ямар нэг зохицуулалт тусаагүй. Ийнхүү хуулийн төсөл нь Үзэл баримтлалд тусгасан зорилгыг бүрэн хангах боломжгүй байгааг тогтоож чадаагүй нь үр нөлөөний үнэлгээ зохих ёсоор хийгдээгүйг харуулж байна.

¹⁵ Эрүүгийн хууль, 17.8 дугаар зүйл. Эд хөрөнгө устгах, гэмтээх, 17.8 дугаар зүйл. Эд хөрөнгө устгах, гэмтээх.

¹⁶ Зөрчлийн тухай хууль, 8.8 дугаар зүйл. Эд хөрөнгө устгах, гэмтээх.

¹⁷ Зөрчлийн тухай хууль, 10.27 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах.

Хүснэгт 3. Хуулийн төсөл болон үр нөлөөний үнэлгээний агуулгын нийцэл

№	Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн хүрээнд гаргасан дүгнэлт, зөвлөмж
1	Зорилгод хүрэх байдал Дараах гурван хүрээнд авч үзэж, эдгээр нь “хуулийн төслийн зорилго болон түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байна” гэж дүгнэсэн.	Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна гэсэн боловч анхаарах шаардлагатай дараах асуудлыг хөндсөн. - тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх харилцааг огт зохицуулаагүй нь тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн хооронд маргаан үүсэх нөхцөлийг бүрдүүлж болзошгүйг анхаарах; - ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төрөлд “баяжуулалтын тусгай зөвшөөрөл”-ийг шинээр нэмсэн байх бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын дэргэдэх зөвшөөрлийн Зөвлөл нь шинээр бий болгох зөвшөөрлийн талаар дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах хуулийн зохицуулалтайг анхаарах; - геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг зүйл хэлбэрээр боловсруулсан дэвшилтэй хэдий ч зарим зохицуулалтыг анхаарах; - “явцуу ашиг сонирхол” гэдгийг хэрхэн ойлгох, хэн тогтоох зэрэг нь тодорхойгүйн улмаас иргэдийн эрх, хөндөгдөх эрсдэл үүсэж болзошгүй байна.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслөөр баяжуулалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх, мөн уул уурхайн үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааг хуулиар зохицуулж олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан нь практикт хэрэгжих боломжтой болохыг харуулж байна.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл нь ХТХ-ийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдсан, ойлгомжтой байна гэсэн боловч зарим нэр томъёог жигдлэх, ойлгомжтой томъёолох шаардлагатай.
4	Харилцан уялдаа	“Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, заалтууд давхардаагүй, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна” гэж гарсан. Гэвч “хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй боловч төсвийн хуваарилттай холбоотой зохицуулалтыг төслийн 3 дугаар зүйлийн 17/, 18/ дахь хэсэгт тусгасан нь Төсвийн тухай хуулийн зарчимтай нийцэхгүй байна. Мөн хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Дээрхээс үзвэл, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийгдсэн дээрх үнэлгээний хүрээнд хуулийн төслийг сайжруулахад шаардлагатай

нийт 7 бүлэг асуудлаар зөвлөмж өгсөн хэдий ч хууль санаачлагч хуулийн төсөлд шаардлагатай өөрчлөлтийг оруулаагүй бөгөөд саналыг харгалзан үзээгүй байна.

ЗАРДЛЫН ТООЦОО ХИЙСЭН БАЙДАЛ

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

Зардлын тооцоог АҮЭБЯ-ны захиалгаар 2025 онд “Ажиглалт” ХХК гүйцэтгэсэн байна.¹⁸

¹⁸ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, нийтэлсэн огноо: 2026 оны 4 сарын 29-ний өдөр.
https://legalinfo.mn/mn/discussiondetail/17436602043482?type=LIS_LAW&page=1

Тус Зардлын тооцооны тайлан нь ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон

гарах зардлын тооцоог хийх аргачлал¹⁹-д заасан шаардлагуудыг хангасан эсэхийг дор товч дүгнэв.

Хүснэгт 4. Зардлын тооцоо хийх аргачлалд тусгасан шалгуурыг бүрэн хамарсан эсэх

№	Зардлын тооцоо хийх аргачлалд тусгасан шалгуурууд	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Зардлын тооцооны тайлан
1	Хувь хүнд үүсэх зардал	Иргэнд үүсэх үүрэг нь заавал гүйцэтгэх үүрэг биш сайн дурын үндсэн дээр үүсэх үүрэг учраас зардал тооцох шаардлагагүй гэж үзсэн. Боломжит зардал: Хэлэлцүүлэгт оролцох, аливаа асуудлаар гомдол гаргахтай холбоотой зардал үүсэх боломжтой.
2	Хуулийн этгээдэд үүсэх зардал	Зөвхөн баяжуулалтын тусгай зөвшөөрөл шинээр авахтай холбоотой зардлыг тооцсон. Боломжит зардал: Хайгуул, баяжуулалт, чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалттай холбоотой үүргүүдийг биелүүлэх зардал, АМНАТ-ийн өөрчлөлттэй холбоотой зардал, бичил уурхайн тайлантай холбоотой зардлууд үүсэх боломжтой.
3	Төрийн байгууллагад үүсэх зардал	Төрд ачаалал, зардал үүсэхээргүй байна гэж дүгнэсэн. Боломжит зардал: Чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтад дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зардал, орон нутгийн ЗД, ИТХ нь дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зардал үүсэх боломжтой.
4	Нэмэлт зардал	Тооцоогүй
5	Зардал, үр өгөөжийн харьцаа	Тодорхойлоогүй
6	Зардлыг бууруулах санал	Зардал бууруулах санал тодорхойлоогүй

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Зардлын тооцоо нь үүсэх боломжтой зардлуудыг

бүрэн тодорхойлоогүй, зардал үр өгөөжийн харьцааг тодорхойлоогүй, зардал бууруулах санал дэвшүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний талаар:

- Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 сарын 02-ны өдөр <https://d.parliament.mn/>-д сайтад байршуулсан Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд нийцээгүй буюу төлөвлөх үе шатыг дутуу хэрэгжүүлж, хэрэгжүүлэх үе шатыг алгасаж үнэлэх үе

шатыг зохих ёсоор гүйцэтгээгүй байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, шинжилгээнд үндэслэн байх зарчим, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсгийг зөрчжээ.

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд хууль тогтоомж боловсруулах үе шатны эхлэл нь хэрэгжилтийн үр дагаврын судалгаа байхаар заасан бөгөөд судалгааны дүгнэлт, саналд үндэслэж хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулахаар хуульчилсан. Гэвч Монгол Улсын Засгийн

¹⁹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207336&showType=1>

газраас 2026 оны 6 сарын 02-ны өдөр <https://d.parliament.mn/>-д сайтад байршуулсан Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ болон хуулийн үзэл баримтлал нь хоорондоо уялдаагүй. Энэ нь Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах хэрэгжилтийн үр дагаврын судалгааг төслийг боловсруулахаас өмнө хийсэн эсэх, хуулийн төсөл нь ийнхүү хийгдсэн судалгаандаа үндэслэсэн эсэх нь эргэлзээтэй байна.

- Уг судалгааны тайлан болон үзэл баримтлал, хуулийн төслийн агуулгын зөрүү, тайланг ил болгосон хугацааг харвал үнэлгээг үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулсны дараа бүрдүүлбэр хангах зорилгоор богино хугацаанд хэлбэрийн төдий гүйцэтгэсэн байх магадлалтай байна.
- Иймд 2025 оны Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээг бодит тоо мэдээнд үндэслээгүй, судалгааны “муу жишиг” гэж үзэж байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний талаар:

- Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд холбогдох тоо баримт, тооцоо судалгааг үндэслэх, салбарын мэргэжилтэн, төрийн бус байгууллага, хуулийн хэрэгжилтийг хариуцах этгээд, нөлөөлөлд өртөх этгээдийн оролцоог хангах шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

- УИХ-ын Тамгын газраас Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-т заасны дагуу хийх хууль зүйн дүгнэлтэд хуулийн төсөл боловсруулах ажлын эрэмбэ, дараалал болон судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчим, түүнтэй холбоотой хуулийн шаардлагыг нарийвчлан шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх;
- Дээрх дүгнэлтэд үндэслэн хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд ХТгХ-ийн

- Үр нөлөөний үнэлгээний зарим дүгнэлтүүд хоорондоо агуулгын зөрчилтэй төдийгүй хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн болон хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарлах эрсдэлтэй зохицуулалтыг илрүүлж чадаагүй.
- Үр нөлөөний үнэлгээгээр хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой давхардсан, зохицуулалт агуулсан эсэхийг шалган тогтоох шаардлагатай. Харин бусад хууль тогтоомжтой давхардсан буюу зохицуулалтын нэмэлт ач холбогдолгүй зохицуулалтыг шалган тогтоогоогүй.
- Хуулийн төсөл нь Үзэл баримтлалд нийцэж буй эсэх буюу үзэл баримтлалд заасан зорилгыг хангаж чадах эсэхийг бүрэн үнэлээгүй байна.
- Үр нөлөөний үнэлгээний тайлангийн хүрээнд өгсөн зөвлөмжийн мөрөөр хуулийн төсөлд сайжруулалт хийсэн эсэх нь тодорхойгүй байгаа нь тус судалгааны ач холбогдлыг бууруулж байна.

Хуулийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцсон талаар:

- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг бүрэн тооцоогүй, зардал үр өгөөжийн харьцааг тодорхойлоогүй, зардал бууруулах санал дэвшүүлээгүй буюу холбогдох аргачлалын бүрэн баримтлаагүй байна.

хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;

- Цаашид хуулийн төсөл боловсруулах ажлын үндэс болж буй хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний чанарыг сайжруулах, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооны гүйцэтгэл, чанарыг сайжруулах, ялангуяа судалгаа шинжилгээг богино хугацаанд хэлбэрийн төдий гүйцэтгэж буй байдлыг шалган тогтоох тогтолцоог бий болгох шаардлагатай байна.